Хүснэгт 4. Ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

№	Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Хүчтэй
1	Үйлдвэрийн үйл ажиллагааны нөлөөнд үржил шимт хөрс бүхий талбай өртөж ургамлын нөмрөгийн байгалийн унаган төрх алдагдах				х
2	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний үед гарах тоосоор тодорхой талбайн ургамал дарагдах			х	
3	Ашиглалтад өртөх талбайн ургамлын нөмрөг бүхэлдээ устаж үгүй болно			х	
4	Тээврийн хэрэгслийн нөлөөгөөр ургамлын нөмрөг тоосонд дарагдах			х	
Нийт нөлөөллийн 75% нь их, 25% нь хүчтэй гэсэн үнэлгээтэй байгаа нь ургамалд үзүүлэх сөрөг нөлөөлөл ИХ байгааг харуулж байна.					



Зураг 1. Төслийн талбайн нөлөөллийн бүс
Төслийн талбайгаас 50 м зайд шууд нөлөөллийн бүс
Төслийн талбайгаас 100, 150 м зайд шууд бус нөлөөллийн бүсийг авч үзэв.
Төслийн талбайгаас нөлөөллийн бүс татан авч үзэхэд ойр орчин нь үйлдвэр үйлчилгээний газар хамаарагдаж байна. Тиймээс төслийн талбайгаас 100м дотор хараа хяналттай үйл ажиллагаагаа явуулах хэрэгтэй байна.

2.5. Амьтны аймаг

Төслөөс амьтны аймагт үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл нь дараах хүчин зүйлсээр тодорхойлогдоно. Үүнд:

Зарим төрлийн шавжийн амьдрах орчныг устгах.

Төслийн үйл ажиллагаанаас гарах дуу чимээнээс амьтан, шувууд дайжих.

Шөнийн цагаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдахад шөнийн амьдралтай амьтдад сөрөг нөлөөлөл учруулна.

Технологийн хаягдлыг зохих журмын дагуу хадгалалгүй ил задгай хаяснаас амьтад хордож болзошгүй. Үйлдвэрийн технологийн горим алдагдсанаас болон байгалийн гэнэтийн аюулт үзэгдлийн улмаас амьтад хордож болзошгүй.

Хүснэгт 5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

		Бага	Дунд	Их	Хүчтэй
1	Зарим төрлийн шавжийн амьдрах орчныг устгах			x	
2	Төслийн үйл ажиллагаанаас гарах дуу чимээнээс амьтан, шувууд дайжих			x	
3	24 цагийн үргэлжилсэн үйл ажиллагааны улмаас шөнийн амьдралтай амьтдын амьдрах орчинд нөлөөлөх		x		
4	Технологийн хаягдлыг зохих журмын дагуу хадгалалгүй ил задгай хаяснаас амьтад хордох		x		
5	Үйлдвэрийн технологийн горим алдагдсанаас болон байгалийн гэнэтийн аюулт үзэгдлийн улмаас амьтад хордох		x		
Нийт нөлөөллийн 60% нь дунд, 40% нь их гэсэн үнэлгээтэй байгаа нь амьтанд үзүүлэх сөрөг нөлөөлөл Дунд байгааг харуулж байна.					

2.6. Хүний эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны нөлөөллийн үнэлгээ:

Эмийн үйлдвэр, химийн бодис, материалын агуулахын доторх зохиомол бичил уур амьсгалын нөхцөл ба агаар сэлгэлт, чийглэг, тоосжилт, мөн хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн хангамж, тоног төхөөрөмж, хяналтын багаж хэрэгслийн техникийн бэлэн бус байдал зэрэг нь ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлс болох нь манай оронд ажиллаж байгаа ижил төстэй бусад байгууллагуудын үйл ажиллагаа, тэнд явуулсан мэргэжлийн хяналтын байгууллагуудын хэмжилт судалгаанаас харагдаж байгаа билээ. Иймээс үйлдвэрийн байрны гэрэлтүүлэг, температур, чийгшилт, орчны тоосжилт, агаар дахь химийн бодисын агууламж зэрэг бичил орчны үзүүлэлтүүд стандарт нормын хэмжээнээс өөр байх нөхцөлд ажиллагсдын эрүүл мэндэд шууд ба шууд бус байдлаар сөрөг нөлөө үзүүлнэ.

Төслийн үйл ажиллагаанаас ажилчдын эрүүл мэнд аюулгүй байдалд учруулах нөлөөллийг энэ хэсэгт тодорхойлов. Тус төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн оноот үнэлгээний аргаар тодорхойлсон ба эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны нөлөөллийн үнэлгээний тайлбарыг доорх хүснэгтэд тус үзүүлэв.

Хүснэгт 7. Хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

		Бага	Дунд	Их	Хүчтэй
1	Ажлын байрны агааржуулалт муутайгаас ажилчид астамтай болох			x	
2	Ажлын байрны зааварчилгаа муу, техник технологитой буруу харьцсанаас аваар осол гарах			x	
3	Химийн бодисыг санамсаргүй байдлаасаа болж хөл гар дээрээ асгах		x		
4	Үйлдвэрийн технологийн явцад химийн бодис байнга уурших			x	
5	Үйлдвэрийн явцад аюулгүй ажиллагааг баримтлаагүйгээс болж ажилчид гэмтэх / тоног төхөөрөмжид гар хөлөө хийж гацаах, цахилгаанд цохиулах г.м/			x	
Нийт нөлөөллийн 20% нь дунд, 80% нь их гэсэн үнэлгээтэй байгаа нь хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл Их байгааг харуулж байна.					

2.7. Нийгэм эдийн засгийн хувьд үйлдвэрийн байршлын хувьд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Хүснэгт 8. Нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

		Бага	Дунд	Их	Хүчтэй
1	Дүүрэгт татвар нэмэгдэх			x	
2	Ажлын байр бий болох			x	
3	Бэртэл, гэмтэл, халдварт өвчин гарах		x		
4	Дотооддоо хүний эрүүл мэндэд хэрэгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх			x	
Нийт нөлөөллийн 20% нь дунд, 80% нь их гэсэн үнэлгээтэй байгаа нь нийгэм эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөлөл Их байгааг харуулж байна.					

Хүснэгт 9. Гол сөрөг нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

№	Нөлөөлөл	Нөлөөллийн хувь	Нөлөөллийн үнэлгээ
A	Физик нөлөөлөл	55.8%	Дунд сөрөг нөлөөтэй
A1	Агаарын чанар	66%	Их сөрөг нөлөөтэй
A2	Газрын гадарга, хэвлий	57.1%	Дунд сөрөг нөлөөтэй
A3	Хөрсөн бүрхэвч	50%	Их сөрөг нөлөөтэй
A4	Ус	50%	Дунд сөрөг нөлөөтэй

В	Биологийн олон янз байдал	67.5%	Дунд зэргийн сөрөг нөлөөтэй
В1	Ургамлын нөмрөг	75%	Их сөрөг нөлөөтэй
В2	Амьтны аймаг	60%	Дунд сөрөг нөлөөтэй
С	Нийгэм-Эдийн засгийн нөлөөлөл	80	Их эерэг нөлөөлөлтэй
С1	Ажил эрхлэлт, дэд бүтэц, эдийн засаг	80%	Их эерэг
С2	Хүний эрүүл мэнд	80%	Их сөрөг нөлөөлөлтэй
	Нийт нөлөөлөл	67.8	Дунд зэргийн сөрөг нөлөөтэй буюу зөвшөөрөх боломжтой

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг ханган тайлагнахтай холбогдсон харилцааг БОАЖСайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тоот Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмыг баримтлан хийж гүйцэтгэлээ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ (агаарын чанар, гадаргын болон газрын доорх усны нөөц хөрсөн бүрхэвч, газрын хэвлий, ургамлын нөмрөг, амьтны аймгийг хамгаалах, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон арга хэмжээ болон тухайн орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг тусган), нөхөн сэргээх арга хэмжээ (техникийн болон биологийн нөхөн сэргээлт), биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ химийн хортой болон аюултай бодисын эрсдэлийг бууруулах арга хэмжээ хог, хаягдлын менежментийн арга хэмжээ, орон нутгийн захиргаа, аймаг нийслэлийн байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын байгууллага, ажлын хэсгийн дүгнэлт, шаардлагаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах үйл ажиллагаа, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр орно.

Аймаг нийслэлийн байгаль орчны газар тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүлээн авсан талаарх мэдээллийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цахим мэдээллийн санд оруулж, хүлээн авсан тухайгаа төсөл хэрэгжүүлэгчийн бүртгүүлсэн цахим шууданд ажлын 5 хоногт багтаан хариу мэдэгдэнэ.

Улирлын чанартай ажилладаг уурхайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг техник болон биологийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг талбай дээр бодитоор нь үнэлэх, хэмжилт хийх боломжтой нөхцөлд зохион байгуулна.

Хөрөнгө санхүүгийн эх үүсвэр: Жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөний байгаль орчны болон ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээний зардалд тусган зарцуулж байх шаардлагатай. Төлөвлөсөн зардлын хэмжээ нь тухайн жил бүр харилцан адилгүй тогтоогдох боломжтой тул тухай бүрд нь тодруулга хийж шинэчлэн тооцно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Эмийн үйлдвэрт ашиглах химийн бодисыг импортлох хэрэглэх, хадгалах, худалдаалах үйл ажиллагаанаас үзүүлж болох болзошгүй болон голлох нөлөөлөлд химийн бодисын хадгалалт, аюулгүйн ажиллагаа болон ажлын байрны эрүүл ахуйн бичил орчны нөлөөлөх байдал нь голлох нөлөөлөлд хамаарахаар байна.

Иймээс төсөл хэрэгжүүлэгч ажиллагсдын ажиллах орчин, хөдөлмөр хамгаалал, химийн бодисын эрсдэлийн менежментийн асуудал дээр гол анхаарлаа хандуулж, 2007 оны 04 дугаар сарын 27–ны өдрийн 151/126/52 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”, MNS 4585-2016. Агаар орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий

шаардлага, MNS 6458:2014. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүний агуулах”, БНБД 21-04-05. Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл, MNS 5566:2005. Аж ахуйн нэгж байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн шаардлага зэрэг стандартуудыг нарийн баримтлан ажиллаж, тухайн бодисын хор аюулгүйн лавлах мэдээлэл (MSDS)-д заагдсаны дагуу химийн бодис бүртэй харьцаж ажиллах шаардлагатай.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах. Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн жил бүрийн 12 дугаар сард багтаан дараа оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон нэмэлт тодотгол үнэлгээний ажлын үр дүнгээр боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үнэлгээний мэргэжлийн зөвлөл хэлэлцэн баталснаас хойш төсөл хэрэгжүүлэгч 1 сарын дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө боловсруулан ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад батлуулахаар хүргүүлнэ.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл, төслийн танилцуулга, төслийн хэрэгжилтийн явц, ашиглаж байгаа техник технологи, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга, энэ журмын 1.5-д заасан бүрдэл хэсгүүд, баримтлах хууль тогтоомж, стандартын шаардлага болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг тодорхой тусгана. Дэд бүтцийн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг бэлтгэл, барьж байгуулах болон ашиглалтын үе шатны батлагдсан төлөвлөгөөтэй уялдуулан жил бүрийн эхний улиралд багтаан боловсруулж батлуулна.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж, батлах. Тухайн төсөлд хийсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үндэслэн боловсруулсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага хянан баталснаар төслийн тухайн жилийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх үүснэ.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэхүү журамд заасан шаардлагыг хангаж боловсруулаагүй бол түүнийг хүлээн авч хянах, батлахаас татгалзах үндэслэл болно.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасны дагуу төсөлд ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээн авч, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн биелэлтийг хянаж, дараагийн жилд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж батална.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах. Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор энэхүү журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг газар дээр нь хянаж, дүгнэх ажлын хэсгийг харьяалагдах аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар энэ журмын 4.1-д заасан хугацаанд байгуулна. Ажлын хэсгийг тухайн аймаг, нийслэлийн байгаль орчны газрын дарга ахлах бөгөөд байгаль орчны газрын уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн нарийн бичгийн дарга байна.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг аймаг, нийслэлийн томилсон ажлын хэсэг газар дээр нь хянаж үнэлсэн нэгдсэн дүн 90 онооноос дээш гүйцэтгэлтэй байвал төсөл хэрэгжүүлэгчээс боловсруулж ирүүлсэн дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан батлах нэг нөхцөл болно.

Аймаг, нийслэлийн байгаль орчны газраас батлагдсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан арга хэмжээ, нөхөн сэргээх, бохирдсон болон доройтсон орчныг цэвэрлэх, сэргээх үүргээ биелүүлээгүй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талаарх мэдээллийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад дүгнэлт гаргуулахаар хүргүүлж болно.

Байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа төсөл хэрэгжүүлэгч 2 жил тутамд байгаль орчны хуваарьт аудит хийлгэн, аудитын тайлан болон аудитын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны газарт ирүүлж, уг аудитын тайлан,

зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланд менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийн талаар бодит мэдээлэл, дүгнэлтийг тусгасан байх бөгөөд хугацааны хувьд давхцаж байвал тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага дүгнэх нөхцөл болгож болно.

Төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт 90 оноо хүрээгүй буюу, хангалтгүй гэж дүгнэгдсэн бол хангалтгүй хийгдсэн ажлыг дараа оны эхний улиралд багтаан гүйцэтгэсэн тохиолдолд дүгнэлтийг дахин гаргуулна. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн ажлыг дутуу хийсэн бол үүнд хамаарахгүй.

Бусад нөхцөл. Байгаль орчныг хамгаалах, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх барьцаа хөрөнгийг төвлөрүүлэх, буцаан олгохтой холбогдсон харилцааг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.15-д заасан журмаар зохицуулна. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг төсөл хэрэгжүүлэгч бүрэн хариуцна.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээн авч дүгнэх, дараа жилийн төлөвлөгөөг хянан батлах асуудлыг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага энэ журмын хавсралт 4 болон 6-д заасан баримт бичиг, мэдээллийн бүрдлийг үндэслэн ажлын 14 хоногт багтааж, шийдвэрлэнэ.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарах зардал/төг/

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	2026 он
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4 590,0
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ногоон байгууламжийн төлөвлөгөө/	600,0
3.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	237,5
7.	Удирдлага зохион байгуулалт	800,0
8.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2 160,0
Нийт дүн		8 387,5
9.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	115,0
Нийт		8 502,5

Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, арга хэмжээний төлөвлөгөө.

Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Урьдчилан сэргийлэх, бууруулах, багасгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль журам, стандарт
1.1. Агаар орчны асуудлаар					
Агуулах болон үйлдвэрийн хөрсний элэгдлээс үүдэлтэй тоосжилт болон химийн бодисын уурших-ийн үр дүнд ялгарах хий зэрэг нь агаарын тоосжилт ба бохирдолтыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх эх үүсвэр болно.	Агааржуулалтын систем холбох, шүүлтүүр тавих	Агуулах болон үйлдвэртээ	1000,0	2026 он	MNS 0012-013:1991. Ажлын байрын агаар. Ажлын байрны агаарын бүс
	Үйлдвэрийн тоосжилт, чимээ шуугиан, чийгшил, гэрэлтүүлгийн байдлыг сайжруулах	Агуулах болон үйлдвэртээ	100,0	2026 он	MNS17.2.3.16-88. "Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам"
	Орчны болон ажлын байрын агаарын бохирдлын байдалд шинжилгээ хийлгэх (жилд 1 удаа)	ОХШХ-т тусгасан	-	2026 он	УСТ3384-82. Агаар мандлын сорьц авахад тавих ерөнхий шаардлага
	Ажилчдын эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажлын байрандаа зориулалтын механик сордог агааржуулагч тавих	Үйлдвэртээ бүх өрөөнд	2000,0	2026 он	MNS 0012-013:1991. Ажлын байрын агаар.

УЛААНБААТАР ХОТЫН БАГАНУУР ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭМИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүн		3 100,0			
1.2. Дуу чимээ					
Ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжөөс үүссэн дуу чимээ орчны шуугианы түвшнийг нэмэгдүүлнэ.	Машин тоног төхөөрөмжийг дуу шуугиан хамгийн бага тарах нөхцөлтэйгээр байршуулан ашиглах	Үйлдвэрийн газар дотор болон химийн бодис ачиж буулгахдаа	500,0	2026 он	MNS ISO 226:2003 дуу чимээ - хэвийн норм-түвшний хэмжээ; MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
	Ажиллагсдыг дуу шуугианаас хамгаалах хэрэгслээр хангаж хэрэгжүүлэх	Ажиллагсад	32 хүн x 40,0 = 800,0	2026 он	
	Дуу шуугианы хэмжилт (1 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийх	Үйлдвэрийн газар дотор болон гаднах талбайд	30,0 x 1 удаа x 3 цэгт = 90,0	2026 он	Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
Дүн		1 390,0			
1.3. Хөрсөн бүрхэвчийн асуудлаар					
Химийн бодисын санамсаргүй алдагдал, ахуйн хог хаягдлыг зориулалтын цэгт төвлөрүүлж графикт хугацаанд ачиж зайлуулахгүй байх зэрэг нь хөрснийг бохирдуулна.	-Бодисыг их хэмжээгээр асгарахаас болгоомжилж үргэлжийн хянуур ажиллах; -Асгарсан тохиолдолд MSDS-д заасны дагуу яаралтай арга хэмжээ авах; -Хүнсний сод, элс, шороо, вермикулитыг бэлэн байлгах	Агуулах болон үйлдвэртээ	100,0	2026 он	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Химийн бодис тээвэрлэх, ачиж буулгах үед хөрс элэгдэж эвдрэл	Үйлдвэр орчмын замыг байнга тордож, арчилж байх	Төслийн орчимд	ҮАЗ-д	2026 он	

**УЛААНБААТАР ХОТЫН БАГАНУУР ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭМИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

орно. Мөн хүн, машины хөдөлгөөний улмаас агуулахын орчмын хөрс элэгдэлд орно. Үйлдвэрийн түүхий эд болон бэлэн болсон зүйлийг ачиж тээвэрлэх үед.					
Дүн			100,0		
1.4. Газрын доорх усны асуудал					
Төслийн явцад усыг их хэмжээгээр, замбараагүй хэрэглэсэн тохиолдолд усны нөөцөд шууд нөлөөлөх магадлалтай	Усны нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, тоолуурын заалтын дагуу ус ашигласны төлбөрийг төлөх	Төслийн хүрээнд	ҮАЗ-д	2026 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль; Усны тухай хууль
Дүн			-		

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал: 4 590,0 мян.төг

Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө /ургамлын нөмрөг хамгаалах/

“Монхимо” ХХК-ийн төслийн онцлогоос хамааран ногоон байгууламжийн төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын хавсралт “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ ажлын хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийг үйлдвэрийн орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэлтийг сайжруулах үүднээс мод тарих ажлыг оруулсан. Ногоон байгууламж байгуулах зөвлөмжийг төслийн БОННУ-д тодорхой тусгаж зардлын тооцоог гаргасан ба энэхүү зардлыг төслийн бүтээн байгуулалтын төсөвт суулгаж өгөх нь зүйтэй.

2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян. төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Төслийн орчинд, ногоон байгууламж бий болгох	Төслийн хүрээнд өөрсдийн хүлэмжид үрслүүлсэн үрсэлгээг шилжүүлэн суулгана	Багануур дүүргийн цэцэрлэгт хүрээлэн болон талбайд байршуулана	84ш х 6000₮ = 504.0 ₮	ҮАЗардал	2026 оны намар	Байгаль орчин, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт. MNS5914:2008; Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хамгаалалт. MNS5916:2008; Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. MNS5918:2023;
Ногоон байгууламжид арчилгаа тордлогоо хийх	Ногоон байгууламжийн усалгаа, тайралт, хэлбэржүүлэлд хийх	Төсөл хэрэгжих орчинд	600,0		2026 он	
Нийт				600,0		

3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Тайлант хугацаанд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ шаардагдаагүй тул төлөвлөгөө, зардал тусгагдаагүй болно.

4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Тайлант хугацаанд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ шаардагдаагүй бөгөөд Үйлдвэрийн бүсэд байрладаг тул, зардал тусгагдаагүй болно.

5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Тайлант хугацаанд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ шаардагдаагүй бөгөөд Үйлдвэрийн бүсэд байрладаг тул, зардал тусгагдаагүй болно.

6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нэгжийн өртөг (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс болж гал гарч, химийн бодис галд өртөж шатвал аюултай нөхцөл байдал үүснэ.	Байгаль хамгаалал, болзошгүй түймрээс урьдчилан сэргийлэх талаар сурталчилгааны самбар хийж байрлуулан, тухай бүрд нь шинэчилж байх	16,6	2026 он	-
	Галын багаж хэрэгсэл авч ашиглахад бэлэн байдлаар байршуулах (амьсгалын нэг бүрийн хамгаалалтын аппарат, галын хор, гал унтраагч, усан шүршүүр, гал унтраах хуурай хэрэгсэл, хөөс, нүүрсхүчлийн хий гэх мэт)	26,8	2026 он	MNS 5566:2005. Аж ахуйн нэгж, байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн шаардлага
	Бодис урвалжуудын хор аюулын зэргийг харуулсан тэмдэг, тэмдэглэгээг монгол тайлбараар дэлгэрэнгүй хийх	8,3	2026 он	MNS 5029:2011. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг.
Химийн бодис их хэмжээгээр асгарвал аюултай нөхцөл байдал үүснэ.	Ослын үед ашиглах гар болон автомат ажиллагаатай дуут дохиололтой болох	20,7	2026 он	MNS 6458:2014. "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүний агуулах"
	Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслийг бэлэн байлгах	29,0	2026 он	

УЛААНБААТАР ХОТЫН БАГАНУУР ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭМИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	Болзошгүй тохиолдлоор химийн бодис асгарсан тохиолдолд хэрэглэх зориулалтын шингээгч, хүнсний сод, хуурай элс, шороо, тогтворжуулагч, үртэс гэх мэт материалуудыг ажлын талбарт бэлэн байлгах асгаралтын иж бүрдэл	136,1	2026 он	Тухайн бодисын хор аюулгүйн лавлах мэдээлэл
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал		237,5		

Тайлбар

“Х”- хяналттай хог хаягдлыг тэмдэглэгээгээр

“Х” гэсэн тэмдэглэгээтэй хог хаягдлыг аюултай хог хаягдалд хамруулах эсэхийг шинжилгээгээр тогтоох ба аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг босго түвшинтэй тэнцүү болон түүнээс дээш хэмжээгээр агуулж байвал “аюултай” гэж үзнэ.

7. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Урьдчилан сэргийлэх, бууруулах, багасгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль журам, стандарт
	Ажиллагсдыг жилд 1 удаа галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт явуулах	Ажилчдад	220,0	2026 он	
Энэхүү тайлангийн сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх	Химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагааны сургалт тогтмол зохиож байх	Ажилчдад	300,0	2026 он	
	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Ажилчдад	ҮАЗ	2026 он	
	Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	Ажилчдад	280,0	2026 он	

**УЛААНБААТАР ХОТЫН БАГАНУУР ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭМИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	Ажлын байранд аюулгүйн шүршүүр болон нүд угаах зориулалтын угаалтуртай болгох	Ажилчдад	ҮАЗ	2026 он	
	Газрын чанарын хянан баталгааг мэргэжлийн байгууллагаар 5 жил тутамд хийлгэх	Ажилчдад	ҮАЗ	5 жил тутамд	Монгол Улсын Газрын тухай хуулийн 58-р зүйл
	Байгаль орчны аудит хийлгэх	Ажилчдад	ҮАЗ	2 жил тутамд	Байгаль орчныг хамгаалах хуулийн 10 ¹ -р зүйлийн дагуу
Дүн			800,0		

8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Ангилал	Эх үүсвэрээс гарах хог хаягдлын төрөл	Код	Аюулын зэрэглэл	Жилд гарах нийт хэмжээ	Дахин боловсруулах	Устгах	Хадгалах	Зөвшөөрөл бүхий байгууллагад нийлүүлэх	Зайлуулахад гарах зардал, мян.төг	Баримтлах стандарт
Ахуйн	Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх	-	-	3,5 тн	+	үгүй	Зориулалтын саванд хадгалах	Багануур дүүргийн ТҮК	646,0	Хог хаягдлын тухай хууль
Ахуйн	Ангилан ялгаж, тус тусад нь хийх савтай болгох	-	-	3,5 тн	+	үгүй	Ангилан ялгаж	Гадна талд	706,5	Хог хаягдлын тухай хууль
Аюултай	Хатуу: хортой бодисын үлдэгдэл агуулсан эсвэл бохирдсон сав, баглаа боодол	5 0109*	X	Үүсэх хэмжээг тодорхойлох боломжгүй	+	-	+		807,5	
Аюултай	Хатуу: шингээгч болон шүүлтүүрийн материал, бохир алчуур, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас	5 0201*	X	Үүсэх хэмжээг тодорхойлох боломжгүй	-	-	+			

НИЙТ	2 160,0	
-------------	----------------	--

БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Нийслэлийн БОГазарт	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах	11-р сар	Нийслэлийн БОГ-ын дүгнэлт	Багануур дүүргийн 3-р хороо
БОУАӨЯ-ны ХБОБХГ-т	-	Тайланг хүлээн авсан актыг БОМТөлөвлөгөөтэй хамт хүргүүлэх	12-р сар	ТЖБОМТБТайланг баталгаажуулах	-
Дүн				1650,0	

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тухайн төслөөс байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг /ус, хөрс, ургамал гэх мэт/ тус бүрд гарах бохирдол, аливаа өөрчлөлтийг хянах шинжилгээний арга аргачлал, хяналт шинжилгээ хийх хугацаа, сорьц авах болох хэмжилт хийх цэгийн байршил, баримтлах стандартууд зэргийг тодорхойлно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчноо хамгаалах, орон нутгийн захиргаа, хяналтын болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой. ОХШХ нь БОХТ-тэгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай.

Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, ногоон хөгжлийн яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Монхимо” ХХК хариуцах болно.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1. Агаарын чанар					
1	Агаарын бохирдлын (NO ₂ , SO ₂ , CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх	Үйлдвэр дотроо	Агаарын найрлага: жил бүрийн 5 сард	67,4	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага; MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага; MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга; MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга; MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм; MNS ISO 226:2003 Дуу чимээ - хэвийн норм, түвшний хэмжээ
	Дуу шуугиан, чичиргээ		Жилд бүрийн 5 сард	22,5	

**УЛААНБААТАР ХОТЫН БАГАНУУР ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭМИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2. Хөрсний бохирдол					
2.1	Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадмий, хром, кобальт, зэс, хар тугалга, манган, никель, цайр	Агуулахын хашаан дотор, хог хаягдлын цэг, хэрэв бохирдол үүссэн бол түүний орчимд	1 цэгт х 2 дээж х жилд 1 удаа (24,0+32,0) Нийт 56,0	25,1	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга; MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга; MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага; MNS ISO 11047:2001 Хөрсний чанар; MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга; MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын 1 жилийн нийт зардлын дүн				115,0	

Төсөл хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөний зардалд 8,502,5 төг төлөвлөж өгсөн.